



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/192

Мандалговь

Бруцеллёзын вакцинжуулалтыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.6, 9.8 9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/182 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

Хоёр. Бруцеллёзын вакцинжуулалтанд хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

Гурав. Технологи т хугацаанд малчдаа бүрэн хамруулж, ажлыг чанартай шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, Мэргэжлийн арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж, вакцинжуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Ш.Мөнхдүүрэн)-д, Захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-очирт)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 29-ний өдрийн
А/1192 дугаар захирамжийн хавсралт

БРУЦЕЛЛЁЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРИЙЛЭХ ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	2020 оны вакцинжуулалтад хамрагдах охин төл				Шаардагдах вакцин		
		Бүгд	Тугал	Хурга	Ишиг	br.Abortus -19	br.Melitensis REV -1	Шингэлэгч
1	Адаацаг	35280	480	18300	16500	480	34800	35.8
2	Баянжаргалан	28600	400	16800	11400	400	28200	29.0
3	Говь-Угтаал	35940	240	21000	14700	240	35700	36.2
4	Гурвансайхан	54720	720	32500	21500	720	54000	55.4
5	Дэлгэрхангай	10660	160	4900	5600	160	10500	10.8
6	Дэлгэрцогт	19740	240	12000	7500	240	19500	20.0
7	Дэрэн	55280	1280	28800	25200	1280	54000	56.6
8	Луус	19140	240	10200	8700	240	18900	19.4
9	Өлзийт	40520	320	23100	17100	320	40200	40.8
10	Өндөршил	42940	640	24300	18000	640	42300	43.6
11	Сайхан-Овоо	34680	480	19500	14700	480	34200	35.2
12	Сайнцагаан	47120	320	26700	20100	320	46800	47.4
13	Хулд	25520	320	13500	11700	320	25200	25.8
14	Цагаандэлгэр	51480	480	30000	21000	480	51000	52.0
15	Эрдэнэдалай	65600	1200	32900	31500	1200	64400	66.8
Дүн		567220	7520	314500	245200	7520	559700	574.7

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР